



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/25

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “г”, 29.1.6-ын “г”, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гарсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын VII цэцэрлэгийн эрхлэгчийн үйл ажиллагаа, ёс зүй, эрх бүхий байгууллагаас тогтоосон хууль дүрмийг сахин ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Бумангэрэл	-БСУГ-ын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Оюунчимэг	-Сайнцагаан сумын ЗДТГ-ын дарга
Гишүүд:	Л.Оюунбаяр	-БСУГ-ын албаны дарга
	Б.Мягмарсүрэн	-БСУГ-ын төсвийн мэргэжилтэн
	Т.Уранбайгаль	-Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Г.Эрдэнэбаатар	-Санхүүгийн хяналт аудитын албаны мэргэжилтэн

Хоёр. Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй явуулж, дүнг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны дотор танилцуулж, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал, дүгнэлтээ ирүүлэхийг ажлын хэсэг /Ц.Бумангэрэл/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



0000000000